

“БНХАУ-ЫН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН ЧИГ ХАНДЛАГА: АМЖИЛТ БА СОРИЛТ” НОМЫН ТУХАЙ

*А.Нямдолжин**

2008 онд ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Хятад судлалын секторын эрдэмтэн судлаач Н.Ариунгуа, Ч.Батцэцэг, Ц.Баатар, Д.Зоригт, Н.Төмөр, Д.Шүрхүү, Ш.Догмийчойдон нар “БНХАУ-ын хөгжлийн өнөөгийн чиг хандлага: амжилт ба сорилт” хамтын бүтээлийг бичиж, хэвлүүлсэн нь 2008 оны ШУА-ийн оны шилдэг эрдэм шинжилгээний бүтээл шалгаруулалтанд өрсөлдөн шагналт байр эзэлсэн байна.

Хамтын бүтээл: Оршил, 1. Хятад дахь улс төр, нийгмийн бодлогын өөрчлөлт, 2. Хятадын эдийн засгийн хөгжлийн шинэ үе шат, 3. Баруун бүс нутгийн хөгжлийн стратеги, 4. ХХI зууны эхэн үеийн БНХАУ-ын гадаад бодлого, дипломат үйл ажиллагаа гэсэн 4 бүлэгтэй 14 зүйлээс бүрджээ.

Дэлхий дахинд даяаршлын үйл явц урьд өмнө байгаагүйгээр хүчтэй өрнөж буй өнөө үед аливаа улс орон хөгжлийнхөө стратегийг, түүний дотор эдийн засгийн хөгжлийнхөө стратегийг тодорхойлохдоо бусад улс орнуудын хөгжлийн чиг хандлага, энэ талын туршлагыг зайлшгүй харгалзан үзэж байх шаардлагатай болж байна. Хятадад өрнөж буй өөрчлөлтүүдийг өөрөөр ойлгох эсвэл хожуу мэдрэх нь энэ улстай харилцахдаа улс төрийн оновчтой бус алхам хийхэд хүргэж болох тул байдлыг аль болох бодитойгоор танин мэдэх нь чухал юм. Өнөөдөр Хятад улсын эдийн засгийн өсөлт дэлхий дахины анхаарлыг татаж ХХI зууныг Хятадын зуун гэж нэрлэх болсон билээ. Сүүлийн жилүүдэд хамгийн их хүн амтай, хамгийн хурдтай хөгжиж буй эдийн засаг, коммунист засаглал бүхий Хятад оронд гарч буй эрс түргэн хувьсал өөрчлөлт, шинэ дипломат бодлого нь эдийн засгийнхаа шинэчлэлийг хэрэгжүүлэх тааламжтай гадаад орчинг бүрдүүлэхэд гадна Хятад улс олон улсын тавцанд их гүрний хэмжээнд бодлого явуулж байгаатай холбоотой юм.

Энэ үүднээс “БНХАУ-ын хөгжлийн өнөөгийн чиг хандлага: амжилт ба сорилт” (УБ. 2008, 12хх) хамтын бүтээл нь орчин үеийн Хятадын улс төр, нийгэм, түүн дотроо үндэстний цөөнхийн асуудал, эдийн засгийн хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжлийн стратеги, Хятадын гадаад бодлогын шинэ стратеги, эдийн засгийн практик үйл ажиллагаа, бүс нутгийн хэмжээн дэх бодлого, хоёр талт эдийн засгийн харилцаа зэрэг асуудлуудыг хөндсөн, эрдэмтэн судлаачдын анализ дүгнэлт дээр тулгуурласан судалгааны дорвитой бүтээл болжээ.

* А.Нямдолжин - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Доктор Н.Ариунгуа уг бүтээлийн I хэсэгт Хятад улс хөгжлийнхөө шинэ шатанд гарсан хэдий ч улс төр, нийгмийн талын олон бэрхшээл сорилтууд, зайлшгүй шийдвэрлэх зохистой асуудлууд байгаагийн дээр Хятад улс хөгжлийн үр дүн, бий болсон зарим алдаа дутагдалдаа дүн шинжилгээ хийж өөрчлөлт шинэчлэлийг юуны түрүүнд нийгмийн баримжаатай болгох, хятадын бүс нутгийн хөгжлийн ялгааг арилгах бодлого хэрэгжүүлж байгааг дурдаад хятадын эдийн засгийн өөрчлөлт шинэчлэл нь хөдөө аж ахуйн салбарт дөнгөж эхлэлийн төдий байгаа бөгөөд хөдөө аж ахуйн салбар бол эдийн засгийн хамгийн хоцрогдсон салбар учир хятадын хөдөө тосгонд нийгмийн талын маш их шийдвэрлэгдээгүй асуудлууд амь бөхтэй байгааг хятадын нийгэм судлаач эрдэмтдийн судалгаан дээр үндэслэн тодорхой өгүүлжээ.

Хятадын үндэстний тэгш эрх, эв нэгдлийг бэхжүүлэх, үндэстний цөөнхийн бүс нутгийн хөгжил, боловсон хүчнийг сургаж хүмүүжүүлэх, бичиг үсэг, хэл соёл, зан үйл, ёс заншил, шашин шүтлэг, сүсэг бишрэлийг хүндэтгэх, төлөвлөгөөт төрөлт зэрэг үндэстний бодлогын тулгамдсан асуудлуудыг доктор Ч.Батцэцэг статистикийн судалгаа, хятадын эрдэмтэн, судлаачдын үнэлэлт, дүгнэлт дээр үндэслэн үечлэн авч үзсэн нь судалгааг улам оновчтой болгосон байна.

Доктор Д.Зоригт 2003 онд Хятадын шинэ удирдлага төр, засгийн эрхэнд гарч ирснээс хойш улс орноо хөгжүүлэх стратегид нь хэд хэдэн шинэ хандлага гарч ирсэн нь эдийн засгаа даяарчлах, хувийн өмчтөний эрхийг хамгаалах, улс төрөө аажмаар либералчлах, дэлхий дахинтай тэр тусмаа АНУ, Европын холбоотой харилцах шинэ загвар буй болгох зэрэг оролдлогууд хэрэгжүүлэхийг зорьж байгаа тухай өгүүлжээ.

БНХАУ нь ЗХА-ийн орны хувьд Монгол Улстай эдийн засаг, гадаад худалдааны өргөн харилцаатай бөгөөд эдийн засгийн цар хүрээгээрээ ялгаатай хэдий ч эдийн засгийн хувьд харилцан хамааралтай бөгөөд тус бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох нь Монгол Улсын эдийн засгийг түргэн хурдацтай хөгжүүлэхэд чухал ач холбогдолтойг доктор Н.Төмөр дурдаад, дэлхийн эдийн засгийн хөгжилд Хятад улсын үзүүлж буй нөлөө, эдийн засгийн гол болоод бусад үзүүлэлтүүдийг статистикийн эх сурвалж ашиглан бодитой шинжилж, оновчтой гаргалгаа хийсэн байна.

Доктор Ц.Баатар Хятад улсын нийгэм эдийн засгийн хөгжлийг судлах нь Монгол Улсын глобал гадаад орчны хүчин зүйлийн судалгаанд ихээхэн ач холбогдолтойг өгүүлээд энэхүү хөгжлийн явцад тулгарсан зарим сул бүрдэл хэсгүүдийг онцлон авч үзсэн нь зах зээлийн эдийн засагт шилжин хөгжиж байгаа Монгол улсын хувьд энэ мэт алдаа, дутагдлыг харгалзан үзвэл зохилтойг дурьджээ.

Эдийн засгийн хөгжлөө түргэтгэх гэсэн тулгамдсан зорилт нь Хятад улс дэлхий дахины үйл хэрэгт идэвхтэй оролцох, гадаад ертөнцөд үүд хаалгаа нээх бодлогын үндэс суурь болж байгааг доктор Д.Шүрхүү, хятадын эрдэмтэн Чэнь Зэхуан тодорхойлсон XXI зууны Хятадын дипломат бодлогын стратегийн 4 чухал тал дээр тулгуурлан харуулжээ.

1978 оноос эдийн засгийн шинэтгэл нээлттэй бодлогыг хэрэгжүүлж эхэлснээс хойш Хятадын баруун бүс нутгийг хөгжүүлэх стратегийн төлөвлөгөөний хүрээнд үндэстний цөөнх оршин суудаг бүс нутгийг хөгжүүлэх нэлээд эрчимтэй бодлого явуулж ирсэнийг үндэстний цөөнхийн нэг бүс нутаг болох Төвдийн Өөртөө засах орны хувьд залуу судлаач Ш.Догмийчойдон авч үзэн, соёл боловсрол, эрүүл мэнд, худалдаа, аялал жуулчлал зэрэг салбарт түлхүү анхааран дэмжин хөрөнгө оруулалт хийж хөгжүүлж байгаа талаар уншигчдад тодорхой мэдээлэл өгсөн байна.

Түүнчлэн доктор Ч.Батцэцэг, Н.Ариунгуа нар бусад үндэстний цөөнх болох ӨМӨЗО, Синьзян-Уйгурын Өөртөө Засах Орны талаар дээр дурьдсан стратегийн төлөвлөгөөний хүрээнд боловсруулж буй төслүүдийг орон тус бүрийн онцлогт тохируулан хэрэгжүүлж байгааг нарийвчлан судалсан байна. Ийнхүү Өвөр Монгол болон Синьзян орон хөгжиж байгаа нь хил залгаа Монгол Улсын хувьд бүс нутгийн хамтын ажиллагаанд оролцоход чухал ач холбогдолтой болохыг судлаачид онцлон тэмдэглэжээ.

Энэхүү хамтын бүтээл нь бүхэлдээ асуудлын мөн чанар, өргөн агуулгыг нээн харуулсан тал бүрийн дүн шинжилгээ, ургуулан гаргасан үнэлэлт дүгнэлт, эрдэм шинжилгээний онолын өндөр түвшинд боловсруулснаараа судлаачдын сонирхлыг татаад зогсохгүй, Монгол Улсын гадаад бодлого боловсруулах, чиг баримжааг тодорхойлох, өмнөд хөрш Хятад улстай харилцах харилцаагаа улам боловсронгуй болгох манай гадаад орчныг судлах судалгаанд чухал ач холбогдолтой бүтээл болсон учир Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл, Гадаад харилцааны яам, их, дээд сургуулийн багш, оюутан хийгээд уншигч өргөн олны хүртээл болсон судалгааны бүтээл болох нь дамжиггүй.